

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО, ИРГЭД, БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦООНЫ ЗАРИМ АСУУДЛУУД

Л.ОЮУНБАТ

*ДХИС-ийн Хилийн албаны
сургуулийн Хилийн албаны
тэнхимийн ахлах багш, дэд
хурандаа*

Товч агуулга: Манай улс нь өргөн уудам нутагтай, олон мянган километр урт хилтэй боловч хүн ам цөөн, эдийн засаг сул байгаа нь хилийн аюулгүй байдалд хамгийн сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа хүчин зүйл юм.

Хил, хязгаар нутаг, түүний хамгаалалтын асуудал чухал байр эзлэхийн дээр хилийн асуудлууд нь улс орнуудын дотоодын хууль дүрмийн хүрээнээс халин гарч олон улсын шинж чанартай болж, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах зайлшгүй шаардлага бий болж байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг нь Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого мөн бөгөөд "Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдмэл

тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна", "байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ" ¹⁹ гэж заасан ч, нэгдмэл тогтолцоо гэж юу болох, түүнийг яаж бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг хэрхэн уялдуулан зохицуулах талаар бүрхэг тусгагдсан, бусад хууль эрх зүйн актуудад бүрэн тусгалаа олоогүй байна.

Түлхүүр үг: Хилийн аюулгүй байдал, хууль, эрх зүй, хил хамгаалалтад ард иргэд, орон нутгийн засаг захиргааг татан оролцуулах.

УДИРТГАЛ

Монгол Улс тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний язгуур эрх ашгаа урьтал болгон, улсын хилийн аюулгүй байдлыг хангах талаар төрөөс бодлого боловсруулан хэрэгжүүлж ирсэн билээ.

Хилийн аюулгүй байдлыг хангах эрхзүйн тогтолцоо нь

¹⁹ Төрөөс хилийн талаар баримтлах бодлого

боловсронгуй болсноор Монгол Улсын үндсэн хууль, түүнтэй нийцүүлэн гарсан бусад хууль эрхзүйн актууд бодитой хэрэгжих улсын хилийг хуулиар хамгаалах, бататгах, хилийн асуудлыг шийдвэрлэх, зохицуулах үндэс бий болох нөхцөл бүрдэнэ.

Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”, 2 дахь хэсэгт “Монгол Улсын хилийг хуулиар бататгана”²⁰

Төрөөс хилийн талаар баримтлах баримт бичгийн 2.1-д “Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох”²¹

Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хилийн талаар баримтлах бодлогын

хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна. “Байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ”²²

Хилийн тухай хуулийн 5.1 дэх хэсэгт “Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн”, 5.2 дахь хэсэгт “Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ”, 5.3 дахь хэсэгт “Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана” гэж тус тус заасан.²³

²⁰ Монгол Улсын Үндсэн хууль УБ 1992

²¹ Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого УБ 2002

²² Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого УБ 2002

²³ Монгол Улсын хилийн тухай хууль УБ 2016

Эдгээр заалт хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд эрхзүйн арга хэрэгсэл чухал болохыг тодорхойлсон үндэслэл юм.

Үндсэн хэсэг:

Улсын хилийн түүх нь ард түмний түүхийн салшгүй хэсэг бөгөөд эртний улсуудын, дундад зууны үеийн, уламжлалт буюу төрт улсын үеийн гэх мэт хөгжлийн урт удаан хугацааг туулсан байдаг.

Орчин үеийн улсын хилийн үүслийг төрт улсын байгуулалтын үүсэлтэй холбож үздэг бөгөөд энэ үеэс хил нь тусгаар тогтнолыг илэрхийлэх болсон.

Улсын хил нь аливаа улсын тусгаар тогтнолын хатуу тогтоосон хязгаар, түүний үйл ажиллагаа болон үзэгдлүүдээр тодорхойлогдох нийгэм-газар зүйн бүс гэж ойлгогддог. Энэхүү бүсэд улс хоорондын газар нутгийн маргаан, мөргөлдөөнийг зохицуулахад олон улсын эрх зүйн хэм хэмжээний ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байна.

Газар нутгийн маргаан нь нэг бус удаа цэргийн мөргөлдөөнд хүргэж тэр нь заримдаа дайн болон өргөжиж байсныг өнгөрсөн түүхээс бид харж болно. Нутаг дэвсгэрийн бэрхшээлтэй асуудлуудад дэлхийн янз бүрийн бүс нутгуудын улс төрийн үйл явц нөлөөлсний үр дүнг

дэлхийн улс төрийн газрын зураг дээрх өөрчлөлтүүдээс харж болно.

Дэлхий нийтэд өрнөж байгаа даяаршил, нийгэм, улс төрийн байдал, манай орны гадаад дотоод бодлого нь улсын хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтын асуудалд шинжлэх ухааны үүднээс хандахын чухлыг харуулж байна. Орчин үеийн дэлхий ертөнцөд гарч буй томоохон өөрчлөлтүүд, хил дамнасан гэмт хэрэг, нийгэм эдийн засгийн хямрал зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, түүний орчинд хурцаар илэрч Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитойгоор нөлөөлөх болов.

Улсын хил зөрчих, зэвсгийн наймаа, террорист, алан хядах ажиллагаа, мансууруулах бодисын худалдаа, зохион байгуулалттай гэмт хэрэг хүрээгээ тэлж байгаа нь түүнтэй тэмцэх Хил хамгаалах байгууллагын ажиллагааг шинэ нөхцөл байдалд шинэлэг арга хэлбэрээр өөрчлөн сайжруулахыг шаардаж байна.

"Аюулгүй байдал" гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарлаж болно. Энэ ойлголт олон салбарт хэрэглэж болох нийтлэг утга агуулагдаж байдаг. Аюулгүй байдлын талаарх энэхүү ойлголтыг Я.Цэвэлийн тайлбар тольд: "аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй", Улс

төрийн нэвтэрхий тольд: "Аюулгүй байдал - дэлхийн нийгэмлэг, улс, нийгэм, хүний амьдралын оршин тогтнох үндсэн чухал язгуур эрх ашиг сонирхол гаднын болон дотоодын аюул заналаас найдвартай хамгаалагдсан байдал", "Британика" нэвтэрхий тольд: "Аюулгүй байдал-амар тайван, бат бэх, итгэлтэй байх нөхцөл байдал, аюул болон эрсдэлээс чөлөөтэй байх" гэж тайлбарлажээ.²⁴

Хилийн аюулгүй байдлыг хангах хүрээний нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн үндсэн акт нь Монгол Улсын хувьд "Үндсэн хууль", "Монгол Улсын хилийн тухай хууль" мөн.

Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь /цаашид "хилийн аюулгүй байдал" гэх/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн.²⁵

"Үндэсний аюулгүй байдлын тухай" хуульд "Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ"²⁶ гэж заажээ. Эндээс үүдэн хилийн аюулгүй байдал гэдгийг "улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах гадаад,

дотоод нөхцөл баталгаатай хангагдах явдал" гэж манай эрдэмтэд үздэг.

Харин Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "хилийн аюулгүй байдал" гэж тусгайлан заагаагүй ч түүний агуулга нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох оршин тогтнохын аюулгүй байдлын хүрээнд нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй болон бүрэн бүтэн байдал гэсэн агуулгаар багтдаг.

Төрийн захиргааны субъект болох Хил хамгаалах байгууллага нь "Монгол Улсын хилийн баталгаажилт, халдашгүй дархан байдлыг хангах, улсын хилийг хамгаалахдаа үндэсний аюулгүй байдлыг хангах тодорхой үүрэг, зорилтыг хэрэгжүүлж байна" гэж "Үндэсний аюулгүй байдлын тухай" хуульд тодорхой заасан байна.

Улсын хил нь улс хоорондын асуудал байдаг учир хил залгаа улстай байгуулсан олон улсын гэрээгээр тодорхойлогдох бөгөөд Монгол Улсын хуулиар баталгаажсан байдаг. Тиймээс түүнийг хамгаалах үйл ажиллагаа нь Монгол Улсын олон улсын хууль,

²⁴ Монгол хэлний тайлбар толь

²⁵ Хилийн тухай хууль 5.1

²⁶ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль

улсын хил, хил орчмын дэглэмийн гэрээ, хил нэвтрэх журмын тухай хэлэлцээр, Монгол Улсын үндсэн хууль, Хилийн тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль болон бусад хуулиуд зэрэг олон улсын болон өөрийн улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд явагддаг.

Дэлхийн улс орнууд өөрийн үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах асуудлыг төрийн бодлогоор дамжуулан ард иргэдийнхээ оролцоонд тулгуурлан хэрэгжүүлдэг байна.

Манай Улсын хувьд хилийн тухай хууль, төрөөс хилийн талаар баримтлах бодлого, улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд орон нутгийн засаг захиргаа, иргэдийг хил хамгаалалтад оролцуулах үндсийг тодорхойлж, олон улсын жишгээр хил хамгаалалтыг зохион байгуулж байгаа боловч хууль, эрх зүйн баримт бичиг болон бусад нөлөөлөх асуудлыг шинжлэх ухааны үндэстэй судлан нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Өнөөгийн байдлаар орон нутгийн бүх шатны удирдах болон төр захиргааны байгууллага, түүний удирдлагатай эд

материалын ойр зуурын дэмжлэг авах, тэмдэглэлт өдрүүдийг хамтарч тэмдэглэх, аж ахуйн чанартай зарим ажил хамтарч гүйцэтгэх төдийхнөөр хязгаарлагдаж байгаагаас бус хил хамгаалалтад иргэдийг үр дүнтэй татан оролцуулах, туслах хүчний үйл ажиллагааг газар орон дээр нь зохион байгуулж, байнгын амьд бодитой ажиллагаатай болгох хэмжээнд хүрч чадаагүй байна.

Дотоодын хууль, эрх зүйн актуудыг боловсронгуй болгох ажлыг НҮБ-ын дүрмийн шаардлага, олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан шинэчлэн сайжруулж, хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Улс болгон тусгаар тогтнолоо хамгаалан бусад оронтой зэрэгцэн оршихын тулд өөрийн аюулгүй байдлыг юуны түрүүнд хангах арга замыг хайдаг.

“Тухайн улсын аюулгүй байдал бусад улсын аюулгүй байдлаас хамаарна” гэж зарим улс төрчид, ихэнх эрдэмтэд үзэж байна. Тийм болохоор олон улсын аюулгүй байдал нь тухайн улсын аюулгүй байдалд, улмаар улсын хил түүний аюулгүй байдалд нөлөөлөх нь гарцаагүй юм.

Улсын хилийн аюулгүй байдлын олон улсын эрх зүйн үндсийг хөгжүүлэхэд олон улсын

байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэнэ. Улс орнуудын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх олон улсын эрх зүйн зарчмын тухай Тунхаглалыг 1970 оны 10 дугаар сарын 24-ний өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээр, оролцогч улс хоорондын харилцаанд зайлшгүй баримтлах зарчмын Тунхаглалыг 1970 оны 8 дугаар сарын 1-ний өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны төгсгөлийн актаар тус тус баталсан байна.

Дээрх баримт бичгүүдэд олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудыг доорх байдлаар баталгаажуулсан байна. Үүнд:

- хүч үл хэрэглэх, хүчээр үл заналхийлэх зарчим
- улс гүрний тэгш бүрэн эрхийн зарчим
- дотоодын хэрэгт үл оролцох зарчим
- нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх зарчим
- улсын хил халдашгүй дархан байх зарчим
- маргааныг эв зүйгээр шийдвэрлэх зарчим
- хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдлэх зарчим
- ард түмнүүд тэгш эрхээр өөртөө засан тогтнох зарчим
- олон улсын үүргээ шударгаар биелүүлэх зарчим

Ихэнх улс орнууд НҮБ-ын дүрмийн шаардлага, бусад олон улсын баримт бичигт үндэслэн өөрийн орны төрөөс хилийн талаар баримтлах бодлогод дээрх зарчмуудыг тусган үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Хамтын болон хилийн аюулгүй байдлыг хангах талаар улс бүр дээрх эрх зүйн актуудад тулгуурлан олон талын ба хоёр талын гэрээний үндсэн дээр асуудлыг шийдвэрлэх бөгөөд тэдгээр нь дээрх баримт бичгийн ямар нэгэн заалтыг зөрчих учиргүй.

Харин хоёр улсын хооронд хамтын аюулгүй байдлаа хангахын тулд найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах тухай гэрээ байгуулахаас гадна хил орчмын нутаг дэвсгэрт хамтран ажиллах талаар тусгай хэлэлцээр байгуулдаг.

Эрх зүй хэмээх багцалсан үзэгдлийг зорилго, ойролцоо болон адилтгах шинжээр нь нэгэн бүрдэл буюу цогцлол болгодог олон тооны хэсгийн уялдаа хамаарлыг эрхзүйн тогтолцоо гэнэ.²⁷

²⁷ О.Амархүү- Эрхзүйн онол УБ 2018

ДҮГНЭЛТ

Хил хамгаалах байгууллага нь улсын хилийг хамгаалах, нөгөөтээгүүр улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх гэсэн хоёр үндсэн үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хил нь газар, газрын хэвлий, агаар, усны мандал гэсэн элементүүдэд хамаарч байна.

Өөрөөр хэлбэл хоёр өөр төрлийн үүрэг, дөрвөн өөр хэсэг бүхий элементийг /нэг хуулиар/ зохицуулж байгаа нь улсын хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрхзүйн тогтолцоо бий болоогүй гэж үзэж байна.

Хилийн тухай хууль нь нийтдээ удаа шинэчлэгдэн батлагдан тухайн цаг үеийн харилцааг зохицуулж чадаж байсан боловч өнөөгийн нөхцөл байдалд хилийн аюулгүй байдлыг хангахад учир дутагдалтай байна.

Иймд хилийн эрхзүйн онол, аргазүйн үндэс, тогтолцоог хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн тодорхойлох зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Хилийн аюулгүй байдлыг хангахад нөлөөлөх дараах үндсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна

- Хөрш улстай сайн хөршийн найрсаг харилцаа, энх тайванч хамтын ажиллагааг бэхжүүлж, хилийн орон зайд олон улсын эрх зүйн зарчмуудыг хэрэгжүүлснээр;

- Хувь хүн, хуулийн этгээдээр хилийн болон хил орчмын дэглэм, боомтод мөрдөх журмыг сахиулснаар;

- Хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий төр захиргааны болон бусад байгууллагуудын хүч хэрэгслийг нэгтгэн ажиллуулснаар.

- Үүсэж болзошгүй аюул заналыг сөрөн зогсож, улмаар арилгахад чиглэгдсэн үндэсний ашиг сонирхол, хилийн аюулгүй байдалд учруулж болох бодит болон болзошгүй аюул заналыг задлан шинжилж, дүгнэлт гаргасны үндсэн дээр хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бий болгох;

- Хилийн аюулгүй байдлыг хангах хүрээний харилцааг зохицуулах, эрх зүйн хэм хэмжээ тогтоох баримт бичгүүдийн заалтуудыг хэрэгжүүлэх тодорхой механизм бүрдүүлэх зэрэг болно.

Ашигласан материал

1.Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, МУ-ын ЗГын тохируулагч агентлаг ХХЕГ, 2002 он.

2.Монгол Улсын Хилийн тухай хууль УБ, 2016 он, МУ-ын ЗГ;

5.Ш.Арвай, “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”, УБ 2005 он;

6. Д.Дашдаваа, “Хилийн аюулгүй байдал” диссертаци;

7.М.Ганболд , Хилийн нэр томъёоны тайлбар толь УБ 2010 он;

3.Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм I, УБ, 2007 он, ХХЕГ;

4.Монгол улсын хил хамгаалалтын тоон судалгааны жагсаалт 2020 он, ХХЕГ;

8.Б.Цэдэн-Иш, Монгол Улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүх, УБ 2003 он;

9.Н.Наранжамц, Улсын хил хамгаалалтын онол-практикийн үндсэн асуудлууд, УБ 2008 он;

10.Ё.Хадхүү, Хилийн албаны бэлтгэл сурах бичиг, УБ, 2013 он;